

ҮНДЭСЛЭЛ:

Монгол улсын эдийн засаг хурдтай өсөж халдварт бус өвчин, осол гэмтлийн тоо ихсэж осол гэмтлээс шалтгаалсан нас баралт сүүлийн жилүүдэд нэмэгдэж байна. Улаанбаатар хотын хүн ам сүүлийн 10 жилд 3 дахин ихсэж улмаар автомашины тоо 450000 байгаа нь 4 хүн тутмын 1 нь автомашин жолоодож байна.

Харин тэдний осол гэмтэл гарсан үед бусдад анхны болон амилуулах тусламж үзүүлэх мэдлэг, чадвар дутмаг байдаг нь бага, дунд, дээд сургууль, жолооны дамжааны сургалтын хөтөлбөрт ордоггүйтэй холбоотой.

Нөгөө талаас хот төлөвлөлтийн дагуу хөгждөггүйгээс Хар цэг буюу замын хөдөлгөөний аюултай цэгүүдийн тоо нэмэгдэж, зам тээврийн осолд өртөгсдийн тоо буурахгүй байна. Тухайлбал, хүн амын нас баралтын 18,9 хувийг зам тээврийн осол гэмтлийн шалтгаан эзэлж, 15-64 насны иргэдийн 4% нь сүүлийн 12 сарын дотор зам тээврийн осолд өртсөнийг судалгаа харуулж байна.

Иймээс зам тээврийн осол гарсан цаг тухайд, газар дээр нь анхны болон амилуулах тусламж үзүүлсэн байдлыг тогтоож жолооч нарын энэ талын мэдлэг чадварыг үнэлэхээр судалгааг Нийслэлийн замын цагдаагийн газар, Тээврийн прокурорын газартай хамтран хийв.

Зорилго: Зам тээврийн осолд өртөгсдөд амилуулах болон анхны тусламж үзүүлсэн байдлыг судлаж жолооч нарын энэ талын мэдлэг, чадварыг үнэлэх

Аргачлал: Зам тээврийн осол гаргасан 35 жолоочоос асуумжийн аргаар судалгааг авч тэдний анхны болон амилуулах суурь тусламжийн мэдлэг, дадлыг үнэлэн судлав.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд оролцсон нийт оролцогчдын 88,5% /31/ эрэгтэй 11,4% нь /4 /эмэгтэй оролцогчид байв.Насны хувьд оролцогчдын 5,7% нь 19 хүртэлх насны 48,5% нь 20-29 насны, 25,7% нь 30-39 насны, 8,5% нь 40-49 насны, 11,4 % нь 50-59 насны оролцогчид эзэлж байна. Судалгаанд оролцогчдыг боловсролын байдлаар авч үзвэл бүрэн дунд-40%, бүүрэн бус дунд 25,7%, дээд боловсролтой 28,5% тусгай мэргэжилтэй 5,7%, байна.

В ангилалын жолооч-54,2%, 25,7% нь ВС, .BCDE-14,2%ыг тус тус эзэлж байна. Жолооч болсон хугацааны 34,2% нь 2010-2014 оных, 28,5% нь 2000-2004 оных,11,4% нь .1995-1999 оных, 11,4% нь .2005-2009 оных, 8,5% нь 1990 оноос өмнө,2,8% нь1990-1994 оных жолооч нар эзэлж байна.

Нийт судалгаанд оролцогчдын 88,2% нь согтууруулах ундаа хэрэглээгүй бол 11,7% нь замын хөдөлгөөнд оролцохдоо согтууруулах ундаа хэрэглэсэн байна. Нийт ослын 74,2% нь хот дотор, 2,8% нь амйгийн төвд, 22,9% нь хотоос гаднах замд тохиолдсон байна. Осол босон газруудыг нэрлэсний дотор Өргөө кино театр, Сансар, Яармаг, 3-р эмнэлгийн урд болон баруун талын замд осол 2 удаагийн давтамжтай гарсан бол Хар цэг гэж нэрлэгдэх байрлалд нийт ослын 17,1% нь тохиолджээ.

Зам тээврийн осол болсон цагийг авч үзвэл 40% нь 19-24 цагт, 22,8% нь 13-18 цагт, 20% нь 0-6 цагт,8,5% нь 7-12 цагт тус тус гарсан байна. Ослын шалтгааныг оролцогчдын 37,1% нь анхаарал болгоомжгүйгээс,22,8% нь явган зорчигчийн буруугаас 8,5% нь замын нөхцлөөс, 5,7% нь согтуу байсан, , 5,7% нь зогсох арга хэмжээ аваагүй, 5,7% нь уулзвар гарц нэвтэрсэн, 5,7% нь эргэх үйлдлээс, 2,8% нь бүрэн бус техник жолоодсноос болсон гэж дүгнэв.

Осол гаргасан автомашины 85,7% нь суудлын, 60% нь Японд үйлдвэрлэсэн, 31,4% нь Солонгос улсад үйлдвэрлэсэн бөгөөд 65,7% нь хувийн, 14,2% нь компанийн машин байсан байна. Хөдөлгөөнд оролцсон автомашины 42,8% нь 2000-2004 он, 28,5% нь 1995-1999 он,14,2% нь 2005-2010 онд үйлдвэрлэсэн байна. Хохирогчдын хүйсээр авч үзвэл 71,4% нь эрэгтэй, 28,5% нь эмэгтэй , насны хувьд 34,2 % нь 30-39, 20% нь 20-29, 14,2% нь 60-аас дээш,11,4% нь 40-49,8,5% нь 50-59, 5,7% нв 19 хүртэлх насны зорчигчид байжээ.

Хохирогчдын 67,8% нь явган зорчигч, 22,8% нь автомашинд, 3,5% нь автобусанд сууж явсан байна. Тээврийн хэрэгсэлд зорчиж явсан зорчигчдын 43,7% нь хамгаалалтын бүстэй, 39,1% нь бүсгүй, 17,3% нь тогтоогдоогүй байна. Зорчигчдын 50% нь урд суудалд, 25% нь арын суудалд, 20% нь хаана суусан нь тодорхойгүй байна. Осолд өртсөн зрчигчдын 54,3% нь гэмтсэн, 45,7% нас барсан байна. Нас барсан зорчигчдын 93,7% нь 24 цагийн дотор нас барсан байна.Гэмтсэн зорчигчдын 46,1% нь хөнгөн, 30,7% нь хүнд, 23% нь хүндэвтэр гэмтжээ. Ослын 50% эь тээвхийн хэрэгсэл тээврийн хэрэгсэлтэй мөргөлдсөн бол, 50% нь тээврийн хэрэгсэл зорчигчийг мөргөсөн байна.

Хэргийн газар цагдаагийн багийн 30 минутын дотор очсныг оролцогчдын 64,2%, эмнэлгийн баг 30 минутын дотор очсныг оролцогчдын 80,7% онцолжээ. Оролцогчдын 67,7 % нь хохирогчдод анхны тусламж үзүүлсэн гэж хариулснаас 47,6% нь анхны тусламжийг түргэн тусламжийн баг, 28,5% нь хажууд байсан хүмүүс гэрч, 14,2% нь хохироогч өөрөө, 9,5% нь цагдаагийн ажилтан үзүүлсэн гэж дурьдсан байна.

Анхны тусламжийг хэрхэн үзүүлсэн бэ гэсэн асуултад 19% нь аюулаас зайлуулсан, 9,5% нь цус тогтоосон, 9,5% нь чиг барьж уясан, 4,7% нь хиймэл амьсгаа хийсэн, бусад тусламж үзүүлсэн-57%, цээж шахах хөдөлгөөн нэг ч тусламж үзүүлэгч хийгээгүй байна. Оролцогчдын 28,5% нь анхны тусламж үр дүнтэй байсан, 61,9% энэ талаар мэдэхгүй, 9,5% нь үр дүнгүй байсан гэжээ.

Анхны тусламжийн талаарх мэдлэг, мэдээллийг хаанаас авч байсан бэ гэсэн асуултад 30% нь бага, дунд болон дээд сургуулийн хичээлээс, 23,3% нь телевизээс, 16,6% нь мэргэжлийн байгууллагын сургалтаас, 13,3% нь сонин сэтгүүлээс гэж хариулжээ. Анхны тусламж үзүүлээгүй оролцогчдын 29,1% нь хэргийн газраас явсан, 29,1% нь энэ талаар мэдлэггүй, 20,8% нь мэдлэгтэй ч хийж байгаагүй, 20,8% нь хийх шаардлага гараагүй гэж хариулсан байна.

ДҮГНЭЛТ

Нийт ослын 74,2% нь хот дотор гарч осол босон газруудыг нэрлэсний дотор Өргөө кино театр, Сансар, Яармаг, 3-р эмнэлгийн урд болон баруун талын замд осол 2 удаагийн давтамжтай гарсан бол Хар цэг гэж нэрлэгдэх байрлалд нийт ослын 17,1% нь тохиолдсон нь энэ цэгүүд дээр дээр осол давтамжтай гарсаар буйг харуулж байна.

Зам тээврийн осол болсон цагийн ихэнх буюу 40% нь 19-24 цагт гарсан нь ажил тарсан ачаалалтай үе болон харанхуй бүрийд гардаг нь харагдаж байна. Ослын шалтгааныг оролцогчдын 37,1% нь анхаарал болгоомжгүйгээс болсон гэж дүгнэсэн байна.

Осол гаргасан автомашины 85,7% нь суудлын, 60% нь Японд үйлдвэрлэсэн, 31,4% нь 42,8% нь 2000-2004 онд үйлдвэрлэснээс харахад 10-аас дээш жил эдэлсэн автомашины осол гарах үзүүлэлт өндөр байна. Нөгөө талаас гаднаас оруулж ирдэг хуучин автомашинууд их байдагтай холбоотой юм.

Хохирогчдын 67,8% нь явган зорчигч байсан байна. Осолд өртсөн зорчигчдын 54,3% нь гэмтсэн, 45,7% нас барж тэдний 93,7% нь 24 цагийн дотор нас барсан байна. Гэмтэгсдын 30,7% нь хүнд гэмтсэн нь амилуулах болон анхны тусламж үзүүлэх шаардлага хэрэгцээ өндөр байгааг харуулж байна.

Хэргийн газар эмнэлгийн баг 30 минутын дотор очсныг оролцогчдын 80,7% онцолжээ. Оролцогчдын 67,7 % нь хохирогчдод анхны тусламж үзүүлсэн гэж хариулснаас 47,6% нь анхны тусламжийг түргэн тусламжийн баг, 28,5% нь хажууд байсан хүмүүс гэрч, 14,2% нь хохироогч өөрөө, 9,5% нь цагдаагийн ажилтан үзүүлсэн гэж дурьдсанаас үзэхэд түргэн тусламж иртэл газар дээр нь тусламж үзүүлэгчдийн оролцоо баг байгааг харуулж байна.

Анхны тусламжийг хэрхэн үзүүлсэн бэ гэсэн асуултад 19% нь аюулаас зайлуулсан, 9,5% нь цус тогтоосон, 9,5% нь чиг барьж уясан, 4,7% нь хиймэл амьсгаа хийсэн, бусад тусламж үзүүлсэн-57%, цээж шахах хөдөлгөөн нэг ч тусламж үзүүлэгч хийгээгүй нь хамгийн үзүүлбэл зохих тусламжийн мэдлэг чадвар байхгүйг илтгэж байна.

Оролцогчдын 61,9% анхны тусламж үр дүнтэй эсэхийг мэдэхгүй, анхны тусламж үзүүлээгүй оролцогчдын 29,1% нь хэргийн газраас явсан, 29,1% нь энэ талаар мэдлэггүй, 20,8% нь мэдлэгтэй ч хийж байгаагүй, 20,8% нь хийх шаардлага гараагүй гэж хариулснаас үзэхэд мэдлэг, дадлаас гадна хандлага ч дутмаг байгааг харуулж байна.

ЗӨВЛӨМЖ

1. Ослын үед гарах гэмтэл, нас баралтыг бууруулахын тулд анхан шатны болон амилуулах тусламжийн талаар олон нийтийн мэдлэг хандлага дадлыг сайжруулах, сургалт зохион байгуулах
2. Мэргэжлийн болон жолооны сургалтад анхан шатны болон амилуулах тусламжийн сургалтын хөтөлбөрийг оруулах
3. Хар цэгүүд дээрх авто ослын байдалд нарийвчилсан дүн шинжилгээ хийж цаашид эдгээр цэгүүд дээр салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах